

МОНГОЛ УЛСЫН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2009 оны 09 дүгээр
сарын 04-ны өдөр

Улаанбаатар
хот

Дугаар 204

Журам батлах тухай

“Хүнсний тухай” хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн төрөл бүрийн хоол, ундаа, нарийн боов хийх технологи, ажилбарыг мэргэшлийн өндөр түвшинд эзэмшиж, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг олон төрлийн, амт чанар, шим тэжээл сайтай эрүүл хоол, бүтээгдэхүүнээр хангаж хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хөдөлмөрийн амжилт гаргасан мэргэжлийн өндөр ур чадвар бүхий тогооч, нарийн боовчин, мэргэжилтнийг шалгаруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулан нарийн технологиор төрөл бүрийн хоол, ундаа, нарийн боовны үйлдвэрлэл явуулж байгаа мэргэжлийн өндөр ур чадвар бүхий мэргэшсэн ажилтанд журмын дагуу “Мастер тогооч” цол олгож байсугай.

2. Монгол Улсын “Мастер тогооч” цол олгох журмыг хавсралтаар баталсугай.

3. Монгол Улсын “Мастер тогооч” цол хүртсэн ажилтанд сар бүр үндсэн цалингийн 20 хүртэл хувийн нэмэгдэл урамшуулал олгож байсугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Үйлдвэр, худалдааны сайдын 2000 оны А-38 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Т.БАДАМЖУНАЙ

МОНГОЛ УЛСЫН “МАСТЕР ТОГООЧ” ЦОЛ ХҮРТЭЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Төрөл бүрийн хоол, ундаа, хийх технологи, ажилбарыг мэргэжлийн өндөр түвшинд эзэмшиж, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг олон төрлийн, амт чанар, шим тэжээл сайтай эрүүл хоол, бүтээгдэхүүнээр хангаж хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хөдөлмөрийн амжилт гаргасан мэргэжлийн өндөр ур чадвар бүхий тогооч, нарийн боовчин, мэргэжилтнийг шалгаруулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Тогоочийн I зэрэгтэй буюу хоолны инженер-технологич мэргэжилтэй, тогооч, эсвэл нарийн боовчны мэргэжлээр 10-аас доошгүй (инженер-технологич бол үйлдвэрлэл дээр 3-аас доошгүй жил) жил үр бүтээлтэй ажилласан хүн Монгол Улсын “Мастер тогооч” цолонд нэрээ дэвшүүлэх эрхтэй.

1.3. Нэр дэвшигч нь Монгол Улсын иргэн байна.

Хоёр. “Мастер тогооч” цолын үндсэн үзүүлэлт, тавигдах шаардлага

2.1. Үндсэн үзүүлэлт

2.1.1. Нэршсэн болон захиалгын дагуу бэлтгэх халуун, хүйтэн зууш, шанцай, шөлтэй хоол, үндсэн болон амтлаг хоол, ундааны жор, технологийг нарийн мэдэж, мэргэжлийн өндөр түвшинд хийж чаддаг, таваглах, чимэглэх аргыг чадварлаг эзэмшсэн байх.

2.1.2 Шанзалсан тахиа, загас, торой, ногоо зэрэг нарийн ажиллагаа шаардагдах хоол, түүнчлэн царцааж бэлтгэх хоол, зориулалтын сав, тавганд бэлтгэдэг хоол, тунгалаг шөл, түүний хачир, мах, ногооны зутан шөл, бүрмэл хоол, нийлмэл хачир, чимэглэл, бүх төрлийн сүмс, крем, чунц, бялууны төрлийг бие даан хийдэг, эдгээрийг бусдад зааж сургах чадварыг эзэмшсэн байх.

2.1.3. Монгол үндэстний уламжлалт болон олон улсад түгээмэл тархсан гол нэрийн (түргэн хоолны төрлүүд, пицца, далайн гаралтай амьтны махаар хийх хоол г.м)-ны жор, бэлтгэх аргыг сайн мэдэж бие даан бэлтгэж чаддаг, бусдад зааж сургах чадварыг эзэмшсэн байх.

2.1.4 Хүлээн авалтын болон тусгай захиалгат үйлчилгээний хоолны цэсийг бие даан зохиож чаддаг байх.

2.1.5 Хоол үйлдвэрлэлийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгслийг ажиллуулах зарчим, сав, багаж хэрэгслийн зориулалтыг мэддэг, ашиглаж чаддаг байх.

2.1.6 Хоол үйлдвэрлэлийн технологийн процессын онцлог, ялгааг сайтар мэддэг, хоол бэлтгэх явцад гардаг физик, хими, биохимийн болон бусад хүчин зүйлийн өөрчлөлтийн талаар зохих мэдлэгтэй, энэ талаар тайлбарлаж чаддаг байх.

2.1.7 Бүтээгдэхүүний хэрчилт, хэвлэлт, чимэглэлтийн аргыг чадварлаг эзэмшсэн байх.

2.1.8 Бэлэн хоол бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт, хоолонд амт оруулагч, бэлдмэл, үйлдвэрийн аргаар хийсэн цуу, сүмс, будагч бодис, өтгөрүүлэгч зэргийг таних талаар өндөр мэдлэгтэй байх.

2.1.9 Хүнс судлал, биохими, хоолны эрүүл ахуй, физиологи, стандарт, техникийн нөхцөл, хэмжил зүйн талаар зохих ойлголттой байх.

2.1.10 Түүхий эд, материалын хэвийн болон боловсруулалтын үед гарах хорогдлыг тооцож чаддаг, материалыг ариг гамтай зарцуулах чадварыг эзэмшсэн байх.

2.1.11 Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд байнга анхаарч энэ талын тогтсон арга барил эзэмшсэн, бусад нарийн мэргэжлийн зөвлөгөө өгөх чадвартай байх.

2.1.12 Тогооч, нарийн боовчин, мэргэжилтнээр ажиллах хугацаандаа 5 –аас доошгүй шинэ нэр төрлийн хоол, бүтээгдэхүүн санаачлан үйлдвэрлэлд нэвтрүүлсэн буюу эсвэл хоолны жор технологийн чиглэлээр гарын авлага, ном, тохимол, сурталчилгааны материал бичсэн байх.

2.2. Тавигдах шаардлага

2.2.1 Хууль, мэргэжлийн хяналтын байгууллагаас сүүлийн 5 жилд торгууль, шийтгэл хүлээгээгүй байх

2.2.2 “Хоолны газрын үйлчилгээ” MNS 4946:2005 стандартын шаардлагыг хангасан байгууллага, нэгжид ажилладаг, тухайн газарт мэргэжлээрээ 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа.

2.2.3 Аймаг, дүүргийн хэмжээний буюу улс, олон улсын чанартай мэргэжлийн уралдааны аль нэгэнд амжилттай оролцож шагналт байранд шалгарсан байх.

2.2.4 Мэргэжлээрээ 3-аас доошгүй хүнийг дагалдуулан сургасан байх.

2.2.5 Дагалдан сургасан тогоочийн овог нэр мэргэжлийн зэрэг, одоо хаана ямар ажил эрхлэдэг, холбоо барих утас тодорхой байх.

2.2.6 Нэр дэвшигчийн мэргэжлийн зэргийн үнэмлэх, боловсролын дипломыг эрх бүхий байгууллага баталгаажуулсан байна.

Гурав. Цол хүртээх журам

3.1. Монгол Улсын “Мастер тогооч” цол хүртээх шалгаруулалтыг 2009 оноос эхлэн сондгой тоотой жилүүдэд тухайн жилийн IV улиралд багтаан явуулна.

3.2. Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага нэр дэвшигчийн тодорхойлт, материалыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан бичгээр ирүүлнэ.

3.3. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Монголын Тогооч нарын холбоо буюу түүний орон нутаг дахь салбар зөвлөлтэй хамтран хэлэлцэж болзлын биелэлтийг хангасан гэж үзвэл цол олгуулахаар нэр дэвшүүлэх хүний холбогдох материалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд тухайн оны 10 сард багтаан ирүүлнэ.

3.4. Монгол Улсын “Мастер тогооч ” цол олгуулахаар нэр дэвшигч нь холбогдсон дараахи материалыг бүрдүүлнэ.

3.4.1. Биелэлтийг үзүүлэлт тус бүрээр тодорхой гаргаж бичсэн байна.

3.4.2. Тухайн хүнийг тодорхойлсон аж ахуйн нэгжийн тодорхойлолт, хамт олны хурлаар хэлэлцсэн тухай протокол, мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээний хуулбар.

3.4.3. Аймаг, дүүргийн засаг даргын Тамгын газар, Тогооч нарын холбооны салбар зөвлөлийн санал, дүгнэлт.

3.4.4. Нэр дэвшигчийн анкет, 3x4 хэмжээтэй 2 хувь цээж зураг

3.4.5. Хууль, хяналтын байгууллага, газрын тодорхойлолт

3.4.6. Шинээр санаачилж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн хоол, бүтээгдэхүүний зурагт альбом, технологийн карт, эсвэл ном, тохимол, бүтээлийн жагсаалт, мэргэжлийн уралдааны шагналын баталгаажуулсан хуулбар

3.5. Шалгалтын комиссын үнэлгээ нь зөвлөлийн шийдвэр гаргах үндэслэл болно.

3.6. Шалгаруулалтад орохтой холбогдон гарах зардлыг нэр дэвшигч хариуцна.

3.7. “Мастер тогооч”-ийн шалгаруулалтыг 12 дугаар сарын 10-ний дотор Улаанбаатар хотод зохион явуулж, онолын мэдлэг, ур чадварын шалгалтанд авбал

зохих нийт онооны 75-аас дээш хувийг хангасан нэр дэвшигчийг тэнцсэн гэж үзэж комиссын протокол гаргана.

3.8. Шалгалтын комиссын үнэлгээ нь зөвлөлийн шийдвэр гаргах үндэслэл болно.

3.9. Тив, дэлхийн чанартай мэргэжлийн уралдаан, тэмцээнд улсаа төлөөлөн оролцож медальт байранд шалгарсан тогоочид Монгол улсын” мастер тогооч” цол хүртээж болно.

3.10. Монгол улсын “Мастер тогооч” цолны шалгаруулалт явуулах, “Мастер тогооч” цолны гэрчилгээ, энгэрийн тэмдэг гардуулахтай холбогдсон зардлыг нэр дэвшигчийг тодорхойлсон аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

3.11. Монгол Улсын “Мастер тогооч” цол олгох зөвлөлийн саналыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар “Мастер тогооч” цол олгож, цол олгосон тухай гэрчилгээ, энгэрийн тэмдгийг ёслол төгөлдөр гардуулна.

3.12. Монгол Улсын “Мастер тогооч” цолны гэрчилгээ, энгэрийн тэмдгийг захиалж хийлгэх ажлыг Монголын Тогооч нарын холбоо хариуцан гүйцэтгэнэ.

3.13. Монгол улсын “Мастер тогооч” нь Монголын тогооч нарын холбооны Ерөнхийлөгчийн 2007 оны 05 дугаар тушаалаар батлагдсан онцлох тэмдэг (лого) бүхий дүрэмт хувцас хэрэглэнэ. Дүрэмт хувцас нь улсын хэмжээнд нэг загварын ажлын болон ёслолын гэсэн 2 янз байна.

3.14. Дүрэмт хувцасны үнийг захиалагч хариуцан төлнө.

Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагаа, аттестатчилал

4.1. Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Шалгаруулалтыг зохион байгуулах зөвлөлийн бүрэлдэхүүн (албан тушаалын нэрээ)- ийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар тухайн жилд томилно. Зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбооны төлөөллийг заавал оруулна. Зөвлөл нь шалгаруулалт явуулахтай холбогдсон мэдээлэл, товыг тухайн жилийн III улиралд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан ёсоор хүргүүлнэ.

4.1.2. Зөвлөл нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичиг шаардлага хангасан гэж үзвэл тухайн нэр дэвшигчийн ажлын байрны зураг авалт хийж, онолын болон ур чадварын шалгалтанд орох эрх олгоно

4.1.3. Монгол Улсын “Мастер тогооч” цол олгох, хүчингүй болгох талаар санал, дүгнэлт гаргах;

4.1.4. Шалгаруулалтын тов тогтоож, явуулах;

4.1.5. Нэр дэвшигчийн онолын болон ур чадварыг үнэлэх комиссын үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнийг батлах;

4.1.6. Аттестатчиллын журам баталж, явуулах

4.2. “Мастер тогооч” цолтны аттестатчлах шалгалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, тушаалаар 4 жил тутамд нэг удаа зохион явуулж байна.

Тайлбар: Анхны аттестатчлах шалгалтыг 2013 оноос явуулж 2009 онд Монгол Улсын “Мастер тогооч” цол хүртсэн хүн заавал орж цолоо баталгаажуулна. 2009 оноос өмнө “Мастер тогооч” цол хүртсэн хүмүүс аттестатчлах шалгалтад сайн дураараа орж цолоо баталгаажуулж болно.

4.3. “Мастер тогооч” цол авсанаас хойш 4 жилийн дотор аттестатчиллын шалгалтад орж “Мастер тогооч” цолоо баталгаажуулан үлдээнэ

4.4. “Мастер тогооч” цолтон нь ажил үүргээ хариуцлагатай биелүүлж, “Мастер” цолны нэр хүндийг өндөрт өргөж ажиллана.

Тав. Цолыг хүчингүй болгох тухай

5.1. Монгол Улсын “Мастер тогооч” нь хоолны газарт мөрдөж байгаа хоол, ундаа, нарийн боов үйлдвэрлэх жор технологи, хоолны газрын үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдсон хууль тогтоомжийг ноцтой хэлбэрээр зөрчсөн тохиолдолд хяналт, шалгалтын байгууллагын тодорхойлолтыг үндэслэн Монгол Улсын “Мастер тогооч” цолыг хүчингүй болгоно.

5.2. Аттестатчилалд хамрагдахаас зайлс хийсэн, хүндэтгэх бус шалтгаанаар хамрагдаагүй болон шалгуур үзүүлэлтийг хангаагүй бол энэ нь тухайн “Мастер тогооч” цолтны цолыг хүчингүй болгох үндэслэл болно.

5.3. Хүчингүй болсон цолны гэрчилгээ, тэмдгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр яаманд эргүүлэн хураалгана.

.....oOo.....